



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/105

Чингис хот

Аргачлал батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ийн "а" хэсэг, 29.3 дахь заалт. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын 2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмыг хэрэгжүүлэх аргачлал"-ыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Аргачлалыг үндэслэн эрхэлсэн салбар орон нутгийн хэмжээнд бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, үйл ажиллагаандаа мөрдөн хоёрдугаар хавсралтад заасан хугацаанд тайлагнаж ажиллахыг агентлаг, байгууллагын дарга, захирал, эрхлэгч, сумдын Засаг дарга, хот, тосгоны Захирагч нарт үүрэг болгосугай.

3. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмыг хэрэгжүүлэх аргачлал"-аар дүгнэж, жилийн үйл ажиллагааны үр дүнгээр хамгийн өндөр үнэлгээ авсан сумдын Засаг даргын Тамгын газар, сумын Засаг даргын Тамгын газрын дарга нарт олгох шагнал урамшууллын хэмжээг гуравдугаар хавсралтаар баталсугай. "

4. Аргачлалын хэрэгжилтийг хангахад шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган батлуулж, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т үүрэг болгосугай.

5. Аргачлалын хэрэгжилтэд хяналт тавьж, дүгнэж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д үүрэг болгосугай.

6. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны А/184 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010343

**БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ЗАХИРГААНЫ  
БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭ ХИЙХ НИЙТЛЭГ ЖУРМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГАЧЛАЛ**

**Нэг. Зорилго**

1.1. Энэхүү аргачлал нь Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг хэрэгжүүлэхэд ерөнхий удирдамж болно.

1.2. Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний цар хүрээг өргөжүүлж, үр өгөөжийг нэмэгдүүлэх, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, удирдан зохицуулах ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газар хариуцан зохион байгуулна.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний удирдлага,  
зохион байгуулалт**

2.1. Бүх шатны захиргааны байгууллага нь өөрийн хариуцсан асуудлын хүрээнд хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлсэн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байна.

2.2. Аймгийн Засаг даргын Тамгын газар нь бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, арга хэмжээг хэрэгжүүлэх, захиргааны байгууллагын үйл ажиллагааг үнэлж дүгнэх ажлыг аймгийн хэмжээнд удирдлага, зохицуулалтаар хангаж, биелэлтэд нь хяналт тавих, мэдээлэх үүргийг хариуцна.

2.3. Энэхүү аргачлалын 2.2-т заасан үүргийг нутаг дэвсгэрийн хүрээнд сумын Засаг дарга, агентлаг, байгууллагын дарга, захирал, эрхлэгч нар тус тус хариуцна.

2.4. Төрийн албан хаагч бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр үнэн зөв, бодитой, холбогдох судалгаа, нотлох баримтын хамт холбогдох албан тушаалтанд гаргаж өгөх үүрэгтэй.

2.5. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын хувьд захиргаа, хүний нөөц, дотоод ажил хариуцсан нэгж, ажилтан бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг нэгтгэж, боловсруулалт хийнэ.

2.6. Сумдад сумын Засаг даргын Тамгын газрын дотоод ажил хариуцсан мэргэжилтэн /эсхүл тухайн чиг үүргийг хариуцсан ажилтан/ бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг нэгтгэж, боловсруулалт хийнэ.

2.7. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс нь аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газарт хяналт-шинжилгээ, үнэлгээг батлагдсан төлөвлөгөөний дагуу “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хийнэ.

**Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөлт,  
төрөл, арга зүй, тайлагналт**

**3.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөлт:**

3.1.1. Захиргааны байгууллага жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөг батална. Төлөвлөгөөнд зорилго, зорилт, хамрагдах байгууллага, хэрэгжүүлэх хугацаа, хамтран оролцох байгууллага зэргийг тусгана.

3.1.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө нь сумын Засаг даргын Тамгын газрын төлөвлөгөө эсхүл тухайн асуудлыг хариуцсан ажилтан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан байна.

3.1.3. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудад хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө нь тухайн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжийн төлөвлөгөө байж болно.

3.1.4. Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө нь аймгийн Засаг даргын Тамгын газарт Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн төлөвлөгөө байна.

### **3.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний төрөл:**

3.2.1. Захиргааны байгууллага нь үнэлгээний зорилгоос хамааруулан үр дүнд суурилсан явцын /тухайн жилийн 07 дугаар сарын 01, 12 дугаар сарын 01-ний дотор/ болон эцсийн /12 сарын 25-ны дотор/ үнэлгээ хийх бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөнд ямар төрлийн үнэлгээ хийх талаар нарийвчлан тусгана.

### **3.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй, тайлагналт:**

3.3.1. Сумдад сумын Засаг даргын Тамгын газрын дарга /эсхүл ажлын хэсэг/ нутаг дэвсгэрийн төрийн байгууллагуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргаж, сумын Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулна.

3.3.2. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын хувьд хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж /эсхүл тухайн чиг үүргийг хариуцсан ажилтан, ажлын хэсэг/ байгууллагынхаа үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, агентлагийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, дүгнэлт, зөвлөмж гаргана.

3.3.3. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж, гаргаж, дүнг удирдлагын зөвлөлд танилцуулна.

3.3.4. Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хоёр удаагийн тайлангийн хугацаанд дараалан ахиц гараагүй бол удааширсан, гурван удаагийн тайлангийн хугацаанд мөн ахиц гараагүй бол тасарсанд тооцож, дээд шатны байгууллагад тайлбарын хамт хүргүүлнэ.

3.3.5. Аймгийн Засаг даргаас сумын Засаг дарга, хотын захирагчтай байгуулсан гэрээний үүргийн биелэлт, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын стратеги төлөвлөгөө, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэхдээ бодлогын баримт бичиг үнэлэх аргачлал, байгууллагын ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааг үнэлэхдээ хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ тооцдог аргачлалаар үнэлнэ.

3.3.6. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд, сумдын Засаг даргын Тамгын газар харъяа нутаг дэвсгэрийн төсвийн байгууллагуудад хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журам, энэхүү аргачлалын дагуу хийнэ.

3.3.7. Сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүд энэ аргачлалын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг холбогдох байгууллагад хүргүүлнэ.

3.3.8. Хэрэгжилтийн тайланг дээд шатны байгууллагад тайлагнахдаа тухайн зорилт, арга хэмжээ, заалтын гүйцэтгэл, үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаана.

Аймгийн Засаг даргын 2021 оны  
 02 дугаар сарын 24 өдрийн А/105  
 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ,  
 БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТАЙЛАГНАХ ХУГАЦАА

№	Тайлангийн төрөл	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх байгууллага	Тайлан хүргүүлэх хугацаа	Тайлан хүлээн авах байгууллага	Давтамж	Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд оруулах хугацаа
1	2	3	4	5	6	7
Бодлогын баримт бичиг	Хөгжлийн зорилтот хөтөлбөр	Сумын Засаг дарга, Захирагч	IX.01	Холбогдох газар, агентлаг	Явцыг- жил тутам, ХШҮ -5 жил тутам	9 дүгээр сар
		Холбогдох газар, агентлаг	IX.05	Холбогдох хэлтэс		
		Холбогдох хэлтэс /дүн болон нэгтгэлийг /	IX.10	ТЗУХэлтэст		
		ТЗУХ	IX.15	ХШҮДАХэлтэст		
	Аймаг Засаг дарга	X.01	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага			
Үндэсний хөтөлбөр	Сумын Засаг дарга, Захирагч	XII.05	Холбогдох газар, агентлаг	Явцыг-жил тутам	1 дүгээр сар	



		Холбогдох газар, агентлаг	XII.15	Холбогдох хэлтэс		
		Холбогдох хэлтэс /дүн болон нэгтгэлийг /	XII.25	ХШҮДАХэлтэст		
		Аймаг Засаг дарга	II.01	Холбогдох яам		
Бодлогын баримт бичиг	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	Сумын Засаг дарга, Захирагч	XII.05	Холбогдох газар, агентлаг	Явцыг жил тутам ХШҮ-2 жил тутам	1 дүгээр сар
		Холбогдох газар, агентлаг	XII.10	Холбогдох хэлтэст		
		Төрийн өмчит хуулийн этгээд, улсын төсөвт үйлдвэрийн газар	XII.10			
		Холбогдох хэлтэс /дүн болон нэгтгэлийг /	XII.15	ХОХБТХэлтэст		
		ХОХБТХэлтэс	XII.20	ХШҮДАХэлтэст		
		Аймаг Засаг дарга	II.01	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага		
Бодлогын баримт бичиг	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр	Сумын Засаг дарга, Захирагч	XII.05 VI.10	Холбогдох газар, агентлаг	Явцыг-жил тутам	1 дүгээр сар
		Холбогдох газар, агентлаг	XII.10 VI.15	Холбогдох хэлтэст		


Бодлогын баримт бичиг		Төрийн өмчит хуулийн этгээд, улсын төсөвт үйлдвэрийн газар	XII.10 VI.15			
		Холбогдох хэлтэс /дүн болон нэгтгэлийг /	XII.15, VI.20	ТЗУХэлтэст		
		ТЗУХэлтэс	XII.20, VI.25	ХШУДАХэлтэст		
		Аймаг Засаг дарга	II.01, VII.10	ЗГХЭГ		
	Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	Сумын Засаг дарга, Захирагч	XII.10	Холбогдох газар, агентлаг	ХШҮ-2 жил тутам, хөндлөнгийн үнэлгээг-4 жил тутам	1 дүгээр сар
		Холбогдох газар, агентлаг	XII.15	Холбогдох хэлтэс		
		Холбогдох хэлтэс /дүн болон нэгтгэлийг /	XII.25	ХШУДАХэлтэст		
		Аймаг Засаг дарга	I.20	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага		
	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	Сумын Засаг дарга, Захирагч	XII.05	Холбогдох газар, агентлаг	Явцыг жил тутам,	1 дүгээр сар
		Холбогдох газар, агентлаг	XII.10	Холбогдох хэлтэс		
		Холбогдох хэлтэс /дүн болон нэгтгэлийг /	XII.15	ТЗУХэлтэст		
		ТЗУХэлтэс	XII.20	ХШУДАХэлтэст		
		Аймаг Засаг дарга	XII.20	ЗГХЭГ		

	Сум, дүүрэг нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	Сумын Засаг дарга, Захирагч / сумын ИТХ-аар хэлэлцүүлж нэгтгэл, дүнг /	XII.30	ХШУДАХэлтэст	Явцыг-жил тутам	
	Аймгийг хөгжүүлэх жилийн төлөвлөгөө	Аймаг Засаг дарга ИТХуралд танилцуулна	II.20	ЗГХЭГ	Явцыг-жил тутам	1 дүгээр сар
Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэл т	Монгол Улсын хууль, УИХ-ын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ- ийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэр	Сумын Засаг дарга, Захирагч	XII.05, V.25	Холбогдох газар, агентлаг	Явцыг-жил тутам	1 дүгээр сар, 6 дугаар сар
		Холбогдох газар, агентлаг	XII.10, VI.01	Холбогдох хэлтэс		
		Төрийн өмчит хуулийн этгээд, улсын төсөвт үйлдвэрийн газар	XII.10, VI.01			
		Холбогдох хэлтэс /дүн болон нэгтгэлийг /	XII.15, VI.05	ТЗУХэлтэст		
		ТЗУХ	XII.20, VI.10	ХШУДАХэлтэст		
		Аймаг Засаг дарга	I.15, VII.01	ЗГХЭГ		
Төсөл	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт	Сумын Засаг дарга, Захирагч	XII.05	Холбогдох газар, агентлаг	Явцыг-жил тутам	1 дүгээр сар
		Холбогдох газар, агентлаг	XII.10	Холбогдох хэлтэс		
		Төрийн өмчит хуулийн этгээд, улсын төсөвт үйлдвэрийн газар	XII.10			

Байгууллагын үйл ажиллагаа	Холбогдох хэлтэс /дүн болон нэгтгэлийг / Аймаг Засаг дарга	ХИ.15	СТСХэлтэст	ХШҮ-4 жил тутам	3 дугаар сар
		II.01	ЗГХЭГ		
	ТЗУХэлтэс Аймаг Засаг дарга	II.01	ХШҮДАХэлтэст	Явцыг-жил тутам	3 дугаар сар
		IV.01	ЗГХЭГ		
	ТЗУХэлтэс Аймаг Засаг дарга	II.01	ХШҮДАХэлтэст	Явцыг-жил тутам	3 дугаар сар
		IV.01	ЗГХЭГ		
Тухайн жилийн үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан	Аймаг Засаг дарга	IV.01	ЗГХЭГ	Явцыг-жил тутам	3 дугаар сар
		IV.01	ЗГХЭГ		



Аймгийн Засаг даргын 2021 оны  
...08 дугаар сарын 26 өдрийн Д/105  
дугаар захирамжийн гуравдугаар хавсралт



**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний  
үр дүнг хэрэгжүүлэх**

1.1. Жилийн үйл ажиллагааны ерөнхий үнэлгээгээр өндөр оноо авч шалгарсан сумдын Засаг даргын Тамгын газрыг 1 дүгээр байр 1000.000 төгрөг  
2 дугаар байр 800.000 төгрөг  
3 дугаар байр 600.000 төгрөгөөр

сумын Засаг даргын Тамгын газрын даргыг 1 дүгээр байр үндсэн цалингийн 80%  
2 дугаар байр үндсэн цалингийн 60%  
3 дугаар байр сарын үндсэн цалингийн 40%-тай тэнцэх мөнгөн урамшуулал олгоно.